



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ДОТООД АУДИТЫН  
ХОРООНЫ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 02

Номгон

Сумдын хоршоо хөгжүүлэх (сум хөгжүүлэх) сангийн  
2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд  
хийсэн хяналт шалгалтын дүнгийн тухай

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, албаны даргын баталсан 07/24 тоот удирдамжийн дагуу сумдын Хоршоо хөгжүүлэх(Сум хөгжүүлэх) сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын үр дүнг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Хяналт шалгалтаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Өмнөх шалгалтаар өгөгдсөн зөвлөмжийг хангалтгүй хэрэгжүүлсэн.
2. Сум хөгжүүлэх сан нь 2022 оны жилийн эцсийн байдлаар 3,754,570,385 төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байгаагийн 943,091,499 төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн байна.(өссөн дүнгээр)
3. Зээлийн эргэн төлөлт, ашиглалт хангалтгүй байна.
4. Зээл, зээлийн хүүг салгаж бүртгэл тусгаагүйгээс тухай жилийн төсвөө батлуулахдаа үйл ажиллагааны зардлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4-т “Сангийн үйл ажиллагааны талаар сумын Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 3.4.7-т “Сангаас олгосон зээлийн тухайн жилийн хүүгийн орлогыг энэ журмын 1.5, 2.7-д заасны дагуу зарцуулах саналаа боловсруулж, жил бүрийн сумын төсөвтэй хамт иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах” гэснийг баримтлан тусгаагүйгээс үйл ажиллагааны зардлыг батлуулаагүй, зориулалт бус зарцуулалтыг хийсэн.
5. Зээлдэгчийн хувийн хэргийн бүрдүүлэлт хангалтгүй, дутуу
6. Барьцаа хөрөнгийг журмын дагуу аваагүй, барьцаа хөрөнгийн үнэлгээ хийгдээгүй
7. Орон тооны бус хяналтын зөвлөлийг ажиллуулаагүй, ажилласан нь үр дүн тооцоогүй.
8. Ажил эрхэлж буй иргэдэд зээл олгосон
9. Сумын Засаг дарга, сан хариуцсан нягтлан бодогч, мэргэжилтэн нар ажилдаа хариуцлагагүй хандсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.7 дах хэсгийг үндэслэн Дотоод аудитын хорооны хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумдын Хоршоо хөгжүүлэх(Сум хөгжүүлэх) сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын үр дүнг баталгаажуулсугай.

642102094

2.Санхүүгийн хяналт, аудитын албанаас гаргасан аудитын ажлын тайлан, үр дүнг хэлэлцээд 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөр илрүүлэн дүгнэж шийдвэрлэснээр тооцсугай.

1.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Аймгийн Засаг дарга(Д.Мөнхсайхан)-д зөвлөсүгэй.

1.1. Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газруудтай байгуулсан гэрээний дагуу, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас гарсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар хамтран ажиллах

2.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт даалгасугай.

2.1. Нас барсан зээлдэгч нарын зээл зээлийн хүүгийн үлдэгдлийг шүүхийн шийдвэр гарсны дараа шийдвэрлэх, найдваргүй авлагыг барагдуулах,

2.2.Зээлийн эргэн төлөлт, зээлдэгч нарын үйл ажиллагаанд тавих хяналтыг эрчимжүүлж ажиллах

2.3.Сангийн үйл ажиллагааны тайланг жил бүр хурлаар хэлэлцүүлж, авлагын үлдэгдлийг баталгаажуулж, ил тод байдлыг хангаж ажиллах

3. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3.1.Хяналт шалгалтын танилцуулгад дурьдсан үүрэг даалгаврыг хэрэгжүүлж холбогдох арга хэмжээг авч ажиллах.

3.2.Зээл олгох сонгон шалгаруулалтыг журмын дагуу хийх

3.3.Шалгалтаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагыг хугацаанд нь барагдуулж, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

3.4.Нас барсан зээлдэгч, шүүхийн шийдвэр дээр байгаа зээл, зээлийн хүүгийн үлдэгдэл тооцоог Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-т заасан бүрдүүлбэрийг хангаж Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлэх.

3.5.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.4-т "Сангийн үйл ажиллагааны талаар сумын Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Зээл, зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх. Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

3.6. Хоршоо хөгжүүлэх(Сум хөгжүүлэх) сангийн зээлийг зөвхөн хоршоонд олгох.

3.7. Зээлийн авлагын үлдэгдлийг баталгаажуулах

4.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг сумдын санхүүгийн албаны дарга нарт даалгасугай.

4.1. Өглөг, авлагын тооцоог тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан, санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдэл, зээлийн мэдээллийн сангийн авлагын үлдэгдэлтэй таарсан эсэхэд тулгалт хийж санхүүгийн тайланг баталгаажуулах

4.2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ыг мөрдөж ажиллах.

4.3. Зээлдэгчдийн зээлийн эргэн төлөлтийн картыг тухай бүр хөтөлж, зээл, зээлийн хүү, тайлант жилийн авлагыг тухай бүр тус тусд нь төлөвлөж тооцоолох, ргэн төлөлтийг хуулийн хүрээнд шаардах

4.5. Барьцаалах үл хөдлөх хөрөнгийг тухайн үеийн зах зээлийн үнэлгээний 70 хүртэл хувиар үнэлж барьцаа хөрөнгийн гэрээ байгуулах, барьцаалбарыг баталгаажуулах, бусдын хөрөнгийг барьцаалбал итгэмжлэл шаардах.

4.6. Хоршоо хөгжүүлэх(сум хөгжүүлэх) сангийн төсөл сонгон шалгаруулах хороо, хяналтын зөвлөлийн гишүүд ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, мэдэгдлийг гаргаж, бүртгэлжүүлэн, дугаар олгож, хяналтын зөвлөлийн даргад мэдэгдэн шилэн дансанд байршуулах.

4.7. Зээлдэгч нарын хувийн хэргийн бүрдлийг журмын дагуу бүрдүүлэн, барьцаа хөрөнгийн гэрчилгээг эх хувиар нь хадгалах нөхцөлийг бүрдүүлэн хадгалах.

4.8. Орон тооны бус хяналтын зөвлөлийн эрх үүргийг хэрэгжүүлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, тогтоолын хэрэгжилтийг тооцох

4.9. Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдэл, зээлийн мэдээллийн сангийн авлагын үлдэгдэл зөрүүг арилгаж ажиллах.

4.10. Төсөл хэрэгжүүлэгч зээлдэгчдыг төслийг зориулалтын дагуу хэрэгжүүлж буй үйл ажиллагааны тайланг гаргуулж сумын иргэд, олон нийтэд ил тод байдлаар тайлагнах.

4.11. Зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэлийг барагдуулах талаар санаачлага гарган ажлын төлөвлөгөө гаргаж үр дүнг тооцсон ажил зохион байгуулж ажиллах.

5. Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны дарга (Л.Жаргалцэцэг)-д даалгасугай.

5.1. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалтын зөвлөмжийн дагуу ажилласан ажлын гүйцэтгэлийг дүгнэж, Дотоод аудитын хороонд танилцуулах.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН